

ВИРТУАЛ ХӨРӨНГӨ ГЭЖ ЮУ ВЭ?



"Виртуал хөрөнгө" гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэний дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг хэлнэ.

Виртуал хөрөнгийн давуу болон сул тал

Давуу тал:

- Хялбар төлбөр тооцооны хэрэгсэл;
- Хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох;
- Өндөр нууцлалтай;
- Түргэн шуурхай;
- Зардал багатай;
- Цаг хугацаа хэмнэсэн;

Сул тал:

- Ханшийн хэлбэлзэл их;
- Террорист этгээдүүдийн санхүүгийн гүйлгээг дамжуулах болон санхүүжүүлэх эрсдэлийг нэмэгдүүлэх;
- Эх үүсвэр тодорхойгүй өмч хөрөнгийг нуун дарагдуулах;

Хэрэв та виртуал хөрөнгө авах гэж байгаа бол дээрх давуу болон сул тал, мөн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан тавигдах шаардлагуудыг харгалзан үзэж тухайн виртуал хөрөнгийн **WHITE PAPER**-тэй заавал танилцан эрсдэлээ тооцоолон шийдвэрээ гаргаарай.



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН WHITE PAPER /ТАНИЛЦУУЛГА/ ГЭЖ ЮУ ВЭ?

WHITE PAPER нь тухайн виртуал хөрөнгийн ирээдүйн эзэмшигчдэд бүтээгдэхүүний онцлог, зорилго, эрсдэлийн талаар мэдээлэл өгөх зорилгоор гаргасан танилцуулга бичиг болно.



White paper нь дараах агуулгаас бүрдэнэ:



Тухайн виртуал хөрөнгө гаргагчийн танилцуулга;



Хуваарилалт, зарцуулалтын төлөвлөгөө;



Зорилго, алсын хараа;



Технологийн танилцуулга;



Бүтээгдэхүүний танилцуулга;



Эзэмшигчдэд бий болох боломж, үр өгөөж;



Бүтээгдэхүүний онцлог, давуу тал;



Эрсдэлийн талаарх мэдээлэл;



Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;